**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2024 оны 03 сарын 29 өдөр | Дугаар А/147 | Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх,
хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр хэсгийн 1 болон 2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга, хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/236, А/189, А/80 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтран баталсан “Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр 2024-2025 онд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хүрээнд “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар батлсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хангаж, олон улсын байгууллагын дэмжлэгийг авч ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т, салбарын бодлого, хөтөлбөрт тусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг)-т, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-д ирүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэжлийн, тусгай мэргэжлийн төв бусад холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

14124О587

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29 өдрийн А/147 дугээр тушаалын хоёрдугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**/2024-2025 он/**

2024 оны 03 дугаар сарын 29-ны өдөр — Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Төсөв | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Нэг. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| 1. | Хүүхдийн эрхийн тухай конвенцын 6,7 дугаар тайланг боловсруулж, "Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл"-ийн хуралд танилцуулах | Тайлан | Тайлан | Бүх яам конвенц болон зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангаа танилцуулсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | ЭМЯ-ны НЭМГ, ЭТҮГ | ХНХЯ, ХЗДХЯ, ГХЯ |
| 2. | Хүүхдийн эрүүл ахуйг үнэлэх, үнэлгээний нэгдсэн аргачлал боловсруулж батлуулах | Батлагдсан шалгуур үнэлгээний аргачлал | - | Эрсдэлийн үнэлгээний аргачлал, маягт батлагдсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | ЭМЯ-ны СХГ, Аймаг, нийслэлийн Засаг дарга | ХНХЯ БШУЯ ХГБХХЕГ ЦЕГ, ОБЕГ, НЭМҮТ |
| 3. | Хүүхдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээний тоо | 2-4 удаа | Арга зүй боловсруулж, шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн байна | Улсын төсөв | 2024-2025 | СЭМҮТ НЭМҮТ | Холбогдох яам, агентлаг Бүх шатны Засаг дарга |
| 4. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх олон улсын сайн загвар, туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлэх, санхүүжилтийн үр ашгийг тооцох аргачлал боловсруулах | Аргачлалын төсөл | - | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих санхүүжилтийн үр ашигтай загвар, аргачлалын төслийг боловсруулсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | ЭМЯ-ны ЭТҮГ, СЭЗГ, ЭХЭМҮТ Хүүхдийн төв сувилал | ХНХЯ, БШУЯ СЯ, ЭЗХЯ |
| 5. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нэн шаардлагатай Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэлгүй уналт, | Тушаал | - | Шаардлагатай эмийн бүртгэлд оруулж, эм хэрэгслээр хангасан байна | Улсын төсөв ЭМДС | 2024-2025 | ЭЭХХЗГ ЭМДЕГ | ХНХЯ, СЯ ХБХХДЕГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | таталтын эсрэг эмийн зохицуулалтыг хийх | | | | | | | |
| 6. | Нярайн скрининг шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах өндөр өртөгтэй шинжилгээний жагсаалтад оруулах | ЭМДҮЗ-ийн тогтоол | - | нярайн скрининг шинжилгээний зардлыг ЭМД-ын сангаас олгодог болсон байна | ЭМДС | 2024-2025 | ЭМЯ-ны БТГ, ЭМДЕГ | ХНХЯ, СЯ |
| 7. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрт үеийн нөхөн сэргээх эмчилгээ үзүүлэх тасаг, нэгжийг байгуулах | Шинээр байгуулсан тасаг, нэгжийн тоо | - | Тасаг, нэгж байгуулсан байна | ЭМДС | 2024-2025 | ЭМЯ-ны ЭТҮГ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, | Аймаг, нийслэлийн ЭМГ |
| 8. | Аймаг, дүүргийн эмнэлгүүдийг нярайн эмчтэй болгож, нярайн эмч нарыг тасралтгүй чадавхжуулах | Нярайн эмчийн тоо | - | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд нярай эмчтэй болж, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулдаг болсон байна | Улсын төсөв | 2024-2026 | ЭМЯ-ны БТГ Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар | ЭМХТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2 |
| **Хоёр.ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 9. | Хүүхэд асрах газрын нялх, балчир насны хүүхдийн бие бялдар, хоол тэжээл, далд өлсгөлөнг тандах, судлах, хариу арга хэмжээг авах, эрүүлжүүлэх | Эрүүлжүүлсэн хүүхдийн тоо | - | Хүүхдийн асрах төвүүдэд тандалт, судалгаа хийж, тайлан, зөвлөмжийг танилцуулсан байна | Улсын төсөв | 2024-2025 | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Аймаг, нийслэлийн ЭМГ | БХБЯ, СХЗГ ХНХЯ |
| 10. | Гэрээр хүмүүждэг, эмээ, өвөө дээрээ өсөж буй, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртдөг нялх, балчир насны хүүхдийг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүлжүүлэх | Хүүхдийн тоо | - | Урьдчилан сэргийлэх үзлэгийг явуулж, эрүүлжүүлэх арга хэмжээг авсан байна | Хариуцах байгууллагын төсөв | 2024-2025 | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Аймаг, нийслэлийн ЭМГ | БХБЯ, СХЗГ ХНХЯ |
| 11. | Аймаг, нийслэлийн өсвөр үеийн кабинетын үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх тусламж үйлчилгээнд хяналт, үнэлгээг хийх | Үнэлгээ хийсэн кабинетын тоо, үнэлгээний дүн | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2022 оны тогтоол | Нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцааг тогтмол үзүүлж, эрүүл мэндийг нь дэмжих ажлыг тогтмол зохион байгуулдаг болсон байна | Улсын төсөв ОУБ | 2024-2025 | ЭМЯ-ны СХГ, ЭТҮГ Аймаг, нийслэлийн ЗДТГ | БСШУЯ, Холбогдох яам, агентлаг |
| 12. | Хүүхдийн сувилал болон сэргээн засах төвийн тусламж, үйлчилгээнд хяналт хийх | Хяналт хийж, зөвлөмж өгсөн | - | Хүүхдийн сэргээн засах төвийн тусламж, үйлчилгээнд хяналт | Улсын төсөв ОУБ | 2024-2025 | ЭМЯ-ны СХГ Аймаг, нийслэлийн | Холбогдох агентлаг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын тоо | | хийж, үр дүнг тооцож, зөвлөмж өгсөн байна | | | Засаг даргын Тамгын газар, | |
| 13. | Өсвөр насны хүүхэд, залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлоход хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлох судалгаа хийх | Судалгааны тайлан | Хүүхдийн эрх хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа 2023 он | Судалгаа зохион байгуулагдсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | СЭМҮТ НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ | БСШУЯ, Холбогдох яам, агентлаг |
| 14. | Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүүхдийг илрүүлэх, үнэлэх аргачлалыг боловсруулах, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарыг чадавхжуулах | Баталсан аргачлал | - | Баталсан аргачлалын дагуу хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | СЭМҮТ, ЭХЭМҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ | ХНХЯ БЕГ |
| 15. | Эмнэлэг түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн албан хаагч, угтах ажилтнуудыг дохионы хэлмэрчээр сургаж бэлтгэх | Бэлтгэсэн албан хаагчдын тоо | - | Дохионы хэлмэрчийн сургалт зохион байгуулсан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | ЭМЯ-ны НЭМГ ХНХЯ | ХБХХЕГ ХГБХХЕГ ЦЕГ |
| 16. | Мэргэжлийн их, дээд сургуультай хамтран эрсдэлт зан үйлтэй хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйг шинэчлэн боловсруулж, үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг сургаж чадавхжуулах | Боловсруулсан арга зүй<br><br>Үйлчилгээ авсан хүүхэд, гэр бүлийн тоо | - | Арга зүй боловсруулж, шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2025 | НЭМҮТ СЭМҮТ АШУҮИС | ХНХЯ БШУЯ Соёлын яам ХГБХХЕГ БЕГ СУГ |
| 17. | Өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвөөс хүүхдэд үзүүлэх "Гэрийн эргэлт"-ийг эх хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн өсөлт, хөгжил, хамгааллалд чиглэсэн цогц үйлчилгээ хэлбэрээр олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулах | Гэрийн эргэлтэд хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн хувь | - | Жил бүр 1 хувиар нэмэгдсэн байна | Улсын төсөв | 2024-2026 | Аймаг, нийслэлийн ЭМГ Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв | ХГБХХЕГ |
| 18. | Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, хөгжлийн | Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн | - | Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны үйл | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2026 | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, | Аймаг, нийслэлийн ЭМГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хоцрогдолтой, эрсдэлтэй хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг, эрт үеийн оролцооны хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх | оролцооны үйл ажиллагааны тоо | | ажиллагааны тоо нэмэгдсэн байна | | | | |
| 19. | Анхан шатны ЭМБ-ын ажилтныг нярайн эрт үеийн оношилгоо хүүхдийн цогц хөгжлийн үзүүлэлтийг хянах арга зүйд сургах, чадавхийг дэмжих | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан хүний тоо | 1 удаагийн сургалтыг 1 дүүрэгт явуулсан | 8 дүүрэг, 18 аймагт сургалт зохион байгуулсан байна | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2026 | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, | Аймаг, нийслэлийн ЭМГ |
| 20. | Хүүхэд бүрийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг хянах үзүүлэлт, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулж, хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц хяналтыг 9, 18, 36, 60 сартайд хийж, мэдээллийн системд бүртгэх | Хяналтад хамрагдсан 9, 18, 36, 60 сартай хүүхдийн хувь | 9, 18 сартай хүүхдийн хамрагдалт ын хувь 85% | Жил бүр хамрагдалтыг 0,5 хувиар нэмэгдүүлж ажилласан байна | Улсын төсөв | 2024-2026 | Аймаг, нийслэлийн ЭМГ | Бүх шатны ЭМБ |
| 21. | Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт, үнэлгээг хийх | Хяналт, үнэлгээнд хамрагдсан ЭМБ-ын тоо, үнэлгээний дүн | - | Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт, үнэлгээг хийж, дүгнэлт, зөвлөмж хүргэсэн байна | Улсын төсөв | 2024-2026 | ЭМЯ-ны СХГ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | Бүх шатны ЭМБ |
| | **Гурав. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ** | | | | | | | |
| 22. | Улсын хэмжээнд 2017-2023 онд “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр үйлчлүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээг дахин хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах | Шинээр бүртгэгдсэн хүүхдийн тоо | 2017-2023 онд 817 хүүхэд | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг дахин үнэлж, мэдээллийг шинэчилсэн байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024/12 | Аймаг, дүүргийн Засаг дарга, ЭМГ ГССҮТ НЭМҮТ | ХГБХХЕГ, ЦЕГ, БЕГ, БШУГ, СУГ, ЦГ, ТББ |
| 23. | “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг сурталчлан таниулах, мөрдүүлэх, салбарын хяналт шалгалтын газрууд хэрэгжилтэд хяналт тавих | Хяналт шалгалтын тайлан, зөвлөмж | ХНХС-ын 2022 оны А/122 дугаар тушаал | Салбар бүр хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөрчлөө арилгасан байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024/12 | ЭМЯ-ны СХГ | Салбарын хяналтын нэгжүүд |
| 24. | Бага насны хүүхдийг хөгжлийг дэмжихэд эцэг, эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах | Төвийн тоо | Бага насны хүүхдийн цогц | Хүүхдийн сэргээн засах төвийг түшиглэсэн жижиг | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024-2026 | ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2 | ХНХЯ, БСШУЯ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний загварыг хөгжүүлэх, жижиг төвийг байгуулах | | хөгжлийг дэмжих чиглэлээр 37 сургагч багш бэлтгэгдсэн | төвийг төрөлжүүлэн байгуулсан байна | | | Аймаг, нийслэлийн ЭМГ | |
| 25. | Осол, гэмтлээс сэргийлэх, нэн ялангуяа хүүхэд өндрөөс унаж гэмтэх, амь насаа алдахаас сэргийлсэн, цонхны хамгаалалт тор байрлуулах талаар зөвлөмж, мэдээллийг хүргэх | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан хүний тоо | 5 төрлийн брошур, 1 анимейшн | Осол, гэмтлээс сэргийлэх чиглэлээр жил бүр 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна | Улсын төсөв | 2024-2025 | НЭМҮТ, ГССҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ | БХБЯ, СХЗГ ХНХЯ |
| 26. | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо | MNS6948:2021 стандарт | Айл, өрхийн судалгаа мэдээлэл гаргаж, хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна. | Улсын төсөв ОУБ-ын санхүүжилт | 2024/12 | ЭМЯ-ны ЭТҮГ, Аймаг, нийслэлийн ЭМГ | Аймаг, нийслэлийн бүх шатны Засаг дарга ХГБХХЕГ, ХХҮЕГ УБЕГ |
| **Дөрөв. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ АЮУЛГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 27. | Эхийн хэвлийд ураг бүрэлдэх үеэс эхлэн 1000 хоногийн хугацаанд хүүхдийн хөгжлийг хянах, өсөлтийг дэмжих, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах | Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэдийн тоо | - | Жирэмсэн болон бага насны хүүхэдтэй эхчүүдэд хүүхдийн хөгжлийг хянах, өсөлтийг дэмжих сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан байна. | Улсын төсөв | 2024/12 | НЭМҮТ Бүх шатны ЭМБ | - |
| 28. | Ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлж, зөвлөмж боловсруулах | Үнэлгээнд хамрагдсан өрхийн тоо | - | ЭМС-ын 2021 оны А/761 дүгээр тушаалын батлагдсан аргачлалын дагуу үнэлгээг хийсэн байна | Хариуцах байгууллагын төсөв | 2024-2025 | Аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМҮТ, Өрх, сумын ЭМТ | Бүх шатны Засаг дарга |
| 29. | Сургууль, цэцэрлэгийн бүсэд хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хориглосон бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтад тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг арилгах | Зөвлөмж, актын тоо | - | Хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгасан байна. | Улсын төсөв | 2024/12 | НЭМҮТ Бүх шатны Засаг дарга | БЕГ БШУГ |
| 30. | Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, эрт илрүүлэх | Арга хэмжээ, оролцсон хүний тоо | - | Жилд 3 доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна. | Улсын төсөв | 2024-2026 | НЭМҮТ, ГССҮТ, ЭХЭМҮТ | Бүх шатны ЭМБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | талаарх ойлголтыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх | | | | | | ЭНЭҮТ-2 СЭМҮТ | |
| 31. | Хүүхдийн зуслан, ордон, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээний төв, амралт, сувиллын газарт нэгдсэн үзлэг шалгалт зохион байгуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх шаардлага зөвлөмж хүргэх, зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд холбогдох хариуцлага тооцох | Илрүүлсэн зөрчил, арга хэмжээний тоо | - | Хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлсэн байна. | Улсын төсөв | 2024/10 | ЭМЯ-ны СХГ Аймаг, нийслэлийн ЗДТГ | Салбарын хяналт шалгалтын газар<br><br>ТББ |
| 32. | Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цагийн болон " Хүүхэд асрах чөлөө"-ний уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэх, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх | Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээ, нөлөөллийн ажлын тоо | Эцэг, эхийн зөвлөлийн тоо 5363 | Жил бүр 3 доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна | Улсын төсөв | 2024-2026 | Бүх эрүүл мэндийн байгууллага | Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭМБ |
| 33. | Хүүхдийн сэтгэл зүйг дэмжих, хүүхэдтэй тэгш харилцах, ялгаварлан гадуурхалтгүй үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын ээлтэй орчин бүрдүүлэх | Хүүхдийн сэтгэл зүй, харилцааг дэмжих ээлтэй орчин бүрдүүлсэн байгууллагын тоо | - | 21 аймаг, 8 дүүргийн нэгдсэн эмнэлэг ээлтэй орчин бүрдүүлсэн байна | Улсын төсөв | 2024-2026 | Аймаг, Нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | ЭМЯ ЭМХТ СЭМҮТ ЭХЭМҮТ |
| 34. | Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын талаарх эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | 8-17 насны хүүхдүүдийн мансууруулах бодисын талаарх эрүүл мэндийн боловсрол олгосон байна. | Улсын төсөв | 2024-2026 | СЭМҮТ НЭМҮТ | Аймаг, Нийслэлийн ЭМГ |

---oOo---